

АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

☐ Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан

☒ Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Дархан сумын Иргэдийн
төлөөлөгчдийн хурлын 2022 оны 05
дугаар тогтоол

Дагаж мөрдөх огноо:

2025.01.02

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан
огноо:

2025.04.09

Байгууллагын нэр:

Дархан хот тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ

Албан тушаалын нэр:

Туслах ажилтан

Ажлын цаг:

8 цаг

Хөдөлмөрийн нөхцөл:

Хэвийн нөхцөл

Нэгжийн нэр:

Цахилгааны хэсэг

Албан тушаалын ангилал,
зэрэглэл:

Дархан сумын Засаг даргын 2025
оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн
А/09 дугаар захирамж

Ажлын байрны албан ёсны
байршил:

Дархан Уул аймаг, Дархан сум 4
дүгээр баг өөрийн байр

Онцгой нөхцөл:

- Шаардлагатай үед илүү цагаар
ажиллах

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайн гэрэлтүүлгийн хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор ахлах мэргэжилтнүүдийн удирдлагын болон цахилгаанчдын багт орж кабель шугамын засвар, үйлчилгээ хийх ажилд газар шорооны ажил хийх, цэвэрлэгээ, сэлбэг хэрэгсэл, багаж тоног төхөөрөмжийг зөөвөрлөх зэрэг ажилд туслах үүргүүдийг гүйцэтгэж, үйл ажиллагааны найдвартай, аюулгүй байдлыг хангаж ажиллах

Албан тушаалын зорилт:

1. Цахилгааны засварын ажлыг гүйцэтгэхэд туслах
2. Ажлын байранд шаардлагатай багаж, материалын бэлтгэл хангах
3. Тоног төхөөрөмжийн цэвэрлэгээ, техникийн туслалцаа үзүүлэх

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах - Т, Хариуцан Гүйцэтгэх - Г Хянах – Х Шийдвэрлэх – Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	1. Цахилгааны мэргэжилтэн болон цахилгаанчдын удирдлага дор кабель угсрах, утас татах, холбох ажилд туслах. Угсралтын явцад хананд нүх өрөмдөх, кабель суваг бэхлэх, хамгаалалтын хоолой байрлуулах	Цахилгааны засварын ажлыг гүйцэтгэхэд туслах	ГТ
	2. Гэрэлтүүлэг, цахилгаан самбар, агаарын шугам, кабель шугам зэрэг тоноглол суурилуулахад туслалцаа үзүүлэх		ГТ
	3. Засварын үед гэмтэлтэй эд ангиудыг солиход сэлбэг материал болон багаж хэрэгслийг бэлэн байлгаж туслан оролцох		ГТ
	4. ХАБЭАхуйн тухай хуулийн 27.5.1-д заасан хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомж, стандартыг хэрэгжүүлэх, өөрийн харьяалах ажлын байр болон үйлдвэрлэлийн орчинд тохирсон дүрэм, журмыг дагаж мөрдөх.		Г
	5. ХАБЭАхуйн тухай хуулийн 27.5.3-т заасан осолд дөхсөн тохиолдлыг бүртгэх болон үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин, үйлдвэрлэлийн орчинд учирч болох аюулыг илрүүлэх, тогтоох, үнэлэх, бууруулах, арилгах талаар хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтанд мэдээлэх, хамтран ажиллах		Г
	6. Шууд удирдах албан тушаалтнаас ажил үүрэгтэй нь холбогдуулж өгсөн үүргийг		Г

	биелүүлэх, уг албан тушаалтанаас өөр зааварчилгаагүй ажилд гарахгүй байх		Г
	7. Үйл ажиллагаа гүйцэтгэхдээ Монгол улсын хууль болон бусад хууль тогтоомж, холбогдох тушаал шийдвэрүүдийг дагаж мөрдөж ажиллах.		
2 дугаар зорилтын хүрээнд	1. Өдөр тутмын ажлын эхэнд хэрэглэгдэх багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийг бүрдүүлж бэлтгэх	Ажлын байранд шаардлагатай багаж, материалын бэлтгэл хангах	ГТ
	2. Ажлын дараа багаж хэрэгслийг цэвэрлэж, зохих байранд хураах		Г
	3. Ашигласан материалын үлдэгдлийг бүртгэх, дууссан материалыг хариуцсан ажилтанд мэдээллэх		Г
	4. Ажлын үеийн багаж хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг шалгаж, гэмтэл гарсан тохиолдолд мэдээллэх		Г
3 дугаар зорилтын хүрээнд	1. Угсралт, засварын дараа цахилгаан тоног төхөөрөмжийг гадаргуугаар нь арчих, тоос шорооноос цэвэрлэх	Тоног төхөөрөмжийн цэвэрлэгээ, техникийн туслалцаа үзүүлэх	ГТ
	2. Энгийн түвшний техникийн туслалцаа үзүүлэх (жишээ нь: боолт чангалах, холболтын орчныг бэхжүүлэх)		ГТ
	3. Тоног төхөөрөмжийг аюулгүй ажиллагааны шаардлага хангахуйц байдалд байлгахад туслах		ГТ
	4. Тоног төхөөрөмжийг хөдлөх, байрлуулахад оролцох		ГТ
	5.Хувийн хамгаалах хэрэгсэл болон ашиглаж буй багажны цэвэр, аюулгүй байдлыг хангах		Г

III. АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

Боловсрол	Бүрэн дунд боловсролтой, Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв (МСҮТ), Политехник коллеж төгссөн байх
Мэргэжил	-
Мэргэшил	-
Туршлага	Мэргэжлээрээ 1-ээс доошгүй жил ажилласан байх

Ур чадвар	Дүн шинжилгээ хийх	- Ажлын явцад тулгарч буй хүндрэл, доголдлыг анзаарч, шалтгаан нөхцөлийг логигоор бодох - Инженер болон ахлах ажилтанд асуудлыг товч тодорхой тайлагнах чадвартай байх
	Асуудал шийдвэрлэх	- Ажлын явцад гарч болзошгүй хүндрэл (багаж дутуу, материал дуусах, аюултай нөхцөл г.м)-ийг хурдан мэдэрч, зохих арга хэмжээ авах - Өөрт ноогдсон ажлыг аюулгүй, оновчтой аргаар гүйцэтгэхэд бие даан оролцох - Асуудлыг нууцлах бус харин цаг алдалгүй мэдэгдэж, ажлын зогсолтгүй байдлыг хангах хандлагатай байх
	Багаар ажиллах	- Цахилгаан инженер болон багийн бусад гишүүдтэй зохицон ажиллах - Үүрэг даалгаврыг зөв ойлгож, хамтран ажиллагсдын ачааллыг нэмэгдүүлэхгүйгээр үүргээ биелүүлэх
	Манлайлах	- Ажлаа хариуцлагатай, тогтмол, цаг хугацаанд нь хийж гүйцэтгэх - Аюулгүй ажиллагааг чанд мөрдөж, бусдад анхааруулж чаддаг байх

IV. АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр: - Ерөнхий инженер - Цахилгааны инженер - Цахилгааны техникч	
Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо:	Бусад харилцах субъект 1. Бусад холбогдох байгууллага

V. АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:	Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:
<u>Албан тушаал:</u> Хүний нөөц / / (Гарын үсэг) (Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр) 2025 оны 04 дүгээр сарын 09-ний өдөр	<u>Байгууллагын нэр:</u> Дархан хот тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ <u>Шийдвэрийн огноо:</u> <u>Дугаар:</u>
Албан тушаалын тодорхойлолтыг хянасан:	
Цахилгааны инженер	/Б.Октябрь/

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:

Байгууллагын нэр: Дархан хот тохижилт үйлчилгээ ОНААТҮГ

Шийдвэрийн огноо:

Дугаар:
(тамга/тэмдэг)

ГАЗРЫН ДАРГА
(Албан тушаал)

.....
(Гарын үсэг)

/З.ЭРДЭНЭБАТ/
(Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр)

2025 оны 04 дүгээр сарын 09-ний өдөр